

Өсөр үеийхэнд зориулсан Библи судлал

Жагсаалт:

1. Есүс шудрага бус зарцтай уулзсан нь (Матай 9:9-14)
2. Есүс найдваргүй өвчтэй хүнтэй уулзсан нь (Марк 2:1-12)
3. Есүс биеэ үнэлэгч эмэгтэйтэй уулзсан нь (Лук 7:36-50)
4. Есүс улс төрчтэй тааралдсан нь (Марк 10:17-27)
5. Есүсийн сургаал: Төөрсөн хүү (Лук 15:11-24)
6. Есүсийн сургаал: Өөр нэгэн төөрсөн хүү (Лук 15:25-32)
7. Есүсийн сургаал: Миний хөрш хэн бэ? (Лук 10:25-37)
8. Есүс хоёр дээрэтчидтэй уулзсан нь (Лук 23:32-43)
9. Итгэл муутай шавь (Иохан 20:19-29)

1. Есүс шударга бус зарцтай уулзсан нь (Матай 9:9-14)

Суурь ойлголт: Есүсийн үед хамт хооллох нь Иудэйчүүдийн нөхөрлөлийн тэмдэг байсан юм. Сүслэг бишрэлтэй хүмүүс татвар хураагчдийг үзэн яддаг байсан, учир нь тэд Ромийн хүчийг булаан авахын тулд татвар хураадаг байсан. (Монгол: Монгол улсыг Хятадууд захирдаг байхад зарим Монголчууд тэдний талд байсантай адил) Татвар хураагчид татвар төлөгчдөөс илүү мөнгө авч өөрсдийнхөө халаасанд хийдэг байсан. Матай Библийн 10 хуулийг заалгуулж байсан, Жишээлбэл: Бүү хулгай хий. Фарисай хүн нь шүтлэгтэнгүүдийн ахлагч байсан хүн юм. (Монголын лам нартай адилхан)

1. Хэрвээ хүн сайхан амьдрахад хангалттай мөнгө байхгүй бол аз жаргалтай байж чадах уу?
 - Татвар хураагч Матайн амьдралыг төсөөл. Түүний цалинг харгалзахгүйгээр амьдарлд нь тохиолдсон муу зүйлүүдийг авч хэлэлц.
 - Матай татвар хураагч байхдаа Бурхан болон түүний хуулийн тухай ямар бодолтой байсан бол?
 - Өнөө үед яагаад хүмүүс мөнгө болон бусдын эд зүйлсийг өөртөө авах нь энгийн болсон бэ?
2. Матай Есүсийг түүний өрөөнд орж ирэх үед юу гэж хэлэх бол гэж та бодсон бэ?
 - Яагаад Есүс Матайгаас: "Чи миний дагалдагч болохыг хүсч байна уу?" гэж асуугагүй бэ?
 - Сүсэгтэнгүүдийн алдартай багш, Матайг өөрийнх нь шавь нартай нэгдээч гэж асуухад Матай юу гэж бодож байсан бол?
 - Есүс үүнээс болж шүүмжлэгдэнэ гэдгээ мэдсээр байж яагаад нэг татвар хураагчыг шавиа болгохыг хүссэн бэ?
3. Матай ширээгээч эмхэлж цэгцлээгүй гэнэт ажилаа орхиод явхад хамт ажиллагсад нь юу гэж бодсон бэ?
 - Матай өндөр орлогтой ажилаа орхиод явсаны учир юу вэ?
4. Өөрийнхөө бүх зүйлсийг орхиод Есүсийг дагаж явснаараа Матай юу олж авсан бэ?
 - Матай Есүст итгэснээс хойш эхнэр, хүүхдүүдийн амьдрал хэрхэн өөрчлөгдсөн бэ?
 - Матай яагаад Есүс болон урьдын хамтрагчидтайгаа хамт оройн хоол идэхийг төлөвлөсөн бэ? (10)
5. Бидний нийгэмд сэтгэлд нийцээгүй хүмүүстэй нийцэхийг хүсдэггүй ямар хүмүүс байдаг вэ?(11)
 - Есүс яагаад бүх хүмүүстэй хамт байхыг хүсдэг вэ?
6. Фарисай хүн яагаад Есүсийг биш харин түүний шавь нарыг шүүмжилсэн бэ?(11)
7. 12-13 дугаар ишлэл дээр Есүс юуг илэрхийлсэн байна вэ?
 - Та өөрийгөө эдгээр 2 бүлгийн алинд нь хамрагдана гэж бодож байна?: Зөвт хүн үү эсвэл нүгэлтэнд үү? (Та дотороо хариулж болно)
8. Матай Есүсийн тухай намтарийг бичсэн юм: Матайн сайн мэдээ. Тэр амьдралаа орхин явж Есүсийг дагсандаа харамсаж байсан гэж та бодож байна уу? (Шалтгаанаа тайлбарла)

Баярт Мэдээний асуулт: Есүс яг одоо танд: "Намайг даг" мөн "Би зөвт хүмүүсийг бус, харин нүгэлтнүүдийг дуудахаар ирсэн" гэж хэлж байна. Та түүнд юу гэж хариулах вэ?

- (Бүгд хариулах хэрэгтэй): Та энэ сэдэвээс юу ойлгож авсан бэ?

2. Есүс найдваргүй өвчтэй хүнтэй уулзсан нь (Марк 2:1-12)

Суурь ойлголт: Есүсийн үед байшингийн дээвэрийг зөөлөн шохойн чулуу мөн тоосгоор барьдаг байжээ. Байшингийн гадна талд нь дээвэр рүү гардаг шат байдаг байсан. Дундаж насны эсвэл хөгшин хүмүүс л тархинд нь цус харваж саа өвчингөөр өвчилдөг байсан. Энэ өвчин туссан хүмүүс ярьж ч чадахгүй хөдлөж ч чаддаггүй байсан. Хүний хүү гэдэг нь Есүс өөрийгөө хэлж байгаа юм.

1. Хэвтэрт байгаг мөн ярьж чадахгүй хүн аз жаргалтай амьдарч чадах уу?
 - Түүний өдөр тутмын амьдралд нь ямар асрамж халамж хэрэгтэй байсан бэ?
 - Түүнийг асарч байсан хүний өдөр тутмын амьдралыг нь төсөөл.
2. Энэ үед бүх Иүдэйчүүд бурханд итгэдэг байсан. Саа өвчин туссаныхаа дараа энэ хүн Бурханы талаар ямар бодолтой болсон бэ?
3. 5-р ишлэл дээр тухайн хүн гэмтэй гэдэгийг тодорхой хэлсэн. Хөдлөж чадахгүй ч гэсэн энэ хүн ямар гэм үйлдсэн байж болох вэ?
 - Таны бодлоор: Өвчин биднийг сайн хүн болгоход өөрчилдөг үү эсвэл бүр ч муу хүн болгодог үү?
4. Саа өвчинтэй хүнийг дэвсгэр дээр хэвтүүлэн хотоор авч явахад нь юу хэцүү байсан бэ?
 - Яагаад хүмүүс өвчтэй хүнийг Есүст хүргэхийн тулд байшингаас гарч зай тавьж өгөөгүй вэ? (4)
 - Хаалгаар орох ямар ч боломж байхгүйг найзууд нь хараад яагаад буцаж яваагүй вэ?
5. Саа өвчтэй хүнийг авчирсан дөрвөн хүн өвчтэй хүнтэй ямар холбоотой байсан бэ? Олон янзын боломжуудыг авч үз (3)
 - Саа өвчтэй хүнийг дээврээр оруулж ирэхийн тулд урьдчилан сэргийлэх ямар арга хэмжээнүүд хэрэгтэй байсан бэ? (Суурь ойлголтоос байшингийн тухай дахин унш)
 - Дэвэрийг хуулж нүх гаргахад тэдэнд ямар багажууд хэрэгтэй байсан бэ мөн багажийг хаанаас олж авсан бэ?
 - Дэвэрийг хуулж нүх гаргаж байхад доор өрөөнөөс нь ямар сургаал сонсогдож байсан бол?
6. Найзууд нь саа өвчтэй хүнийг эдгээхийн тулд Есүсийн өмнө авчирсан. Гэтэл Есүс яагаад тэр хүнийг гэмийг нь эхэлж уучилсан бэ?(5)
 - Есүс яагаад энэ дэс дараалалийг баримталсан бэ? Эхлээд гэм нүглийг нь уучилж дараа нь өвчинийг нь эдгээсэн бэ?
 - Саа өвчтэй хүний хувьд өнгөрсөн амьдралдаа хийсэн гэм нүгэлийн уучлалыг авсан нь ямар утгатай байсан бэ?
7. Та өөртөө байгаа хамгийн хэцүү асуудлынхаа төлөө Есүсээс тусламж гуйлаа гэж бодъёо. “Гэтэл Есүс танд хүү/охин минь чиний гэм нүгэл чинь уучлагдсан” гэж хэлбэл та баярлах уу эсвэл гомдох уу?
 - Хэрвээ танд сонголт байсан бол дараах хоёр зүйлийн алыг нь сонгох вэ? Сайн ухамсар эсвэл хамгийн хэцүү асуудал тань шийдвэрлэгдэх.
 - Саа өвчтэй хүн өөрийгөө аврагдсан гэж мэдсэний дараагаар өвчиндөө хандах хандлага нь хэрхэн өөрчлөгдсөн бэ?
8. 5-р ишлэл дээр Есүс саа өвчтэй хүний бус харин түүний найз нарын итгэлийн тухай өгүүлж байна. Үүнээс авч үзэх юм бол саа өвчтэй хүн Есүстэй уулзахаас өмнө итгэгч биш байсан. Тэгвэл тэр хүн таны бодлоор яг аль ишлэлээс итгэж эхэлсэн бэ?
 - Хуулийн багш нар Есүсийг гэм нүгэл уучилж чаддаг гэдэгт яагаад итгээгүй вэ?(7-8)
9. 9-р ишлэл дээрх Есүсийн тавьсан асуултанд хариул.
 - Тухайн хүнийг эдгээхийн тулд Есүсээс ямар төлөөс гарсан бэ? Түүний гэм нүглийг уучилахын тулд Есүсээс ямар төлөөс шаардагдсан бэ?
 - 10-12 дугаар ишлэл дээр болсон зүйлсийг та өөрөө нүдээрээ харсан гэрч байсан бол Есүсийн тухай ямар бодолтой байх байсан бэ?

Баярт Мэдээний асуулт: Хэрвээ хийсэн гэм нүглээс болж таны зүрх сэтгэл тань шаналж байгаа бол Есүс танд юу хэлж байгааг сонс “ Миний хүү/охин чиний гэм нүгэл чинь уучлагдсан”. Есүс өөрийнхөө амласаныг биелүүлэхийн тулд өөрөө загалмай дээр золиос болсон. Тэгвэл түүний амлалт өнөөдөр таны хувьд ямар утгатай вэ? (Та дотороо хариулж болно)

- (Бүгд хариулах хэрэгтэй): Энэ сэдэвээс та юу ойлгож авсан бэ?

3. Есүс биеэ үнэлэгч эмэгтэйтэй уулзсан нь (Лук 7:36-50)

Суурь ойлголт: 44-46 ишлэлүүд дээр Есүсийн үед хүндэттэй зочидыг хэрхэн хүлээж авдаг байсаныг өгүүлжээ. Хүмүүс хоол идэхдээ газар хажуулдан суудаг байжээ. Тиймээс ямарваа нэгэн хүний хөл нь бохир байвал хүмүүсийн хоол идэх хүслийг бууруулдаг байжээ. Иүдэйчүүдийн ёсоор эмэгтэй хүн танихгүй эрэгтэй хүмүүсийн өмнө үсээ задгай тавихыг хориглодог байсан. Фарисай гэдэг нь Бурханд хүчтэй итгэдэг хүнийг хэлнэ. Симон гэдэг нь Есүсийн дагалдагч биш өөр Симон юм.

1. Таны бодлоор биеэ үнэлдэг хүн аз жаргалтай амьдарч чадах уу?
 - Өөрийн биеэ үнэлдэг энэхүү эмэгтэйтэй хотын бүх хүмүүс мэддэг байсан. Юунаас болж тэр эмэгтэй биеэ үнэлэгч болсон бэ?
2. Фарисай хүн Симоны хувьд амьдралд нь чухал зүйлүүд юу байсан бэ?
 - Симон Есүсийг өөрөө гэртээ зочиноор урьсан боловч яагаад зарц нартаа Түүний хөлийг угаа гэж хэлсэнгүй вэ? (36, 44-46)
 - Симон Есүсийг гэртээ хоолонд урьсан шалтгаан нь юу вэ? Олон янзын хариултуудыг ол. (36)
3. Тэр эмэгтэй яаж Симоны гэрт болон түүний хоололдог өрөөнд орж ирсэн бэ? Олон янзын хариултуудыг ол.
 - Гөлтөгнөн савтай үнэт тос маш их үнэтэй байсан. Тэр эмэгтэй ямар зорилготойгоор хаанаас яаж үнэт тосыг олж авсан бэ? (Олон янзийн хариултыг ол)
4. Фарисай хүний гэрт очивол таатай уур амьсгал өөрийг нь угтаж авахгүйг мэдсээр байж эмэгтэй яагаад тэнд очиж Есүстэй уулзахыг хүссэн бэ?
 - Тэр үед шүтлэгтэй хүмүүс гэмт хүмүүстэй харьцдаггүй байсан. Яагаад эмэгтэй Есүсийг бусдаас өөр гэдэгт итгэж байсан бэ?
5. Эмэгтэй яагаад Есүст хүрэхийг хүссэн бэ?(38)
 - Бидний дургүйцлийг хүргэдэг хүн эсвэл хулган, могой бидэнд хүрвэл юу болох вэ?
 - Есүс эмэгтэйтэй өөрт нь хүрэхэд дургүйцээгүйг авч үзвэл, эмэгтэй юуг ойлгож авсан бэ?
6. Энэ эмэгтэй хамгийн сүүлд хэзээ уйлсан бол?
 - Өөр хүний хөлийг нулимасаараа угаахын тулд хир их нулимас хэрэгтэй вэ?
 - Эмэгтэй яагаад Есүсийн хөлийг нортол тийм их уйлсан бэ?
 - Эмэгтэй яагаад Есүсийн хөлийг алчуураараа юмуу хувцасаараа биш харин үсээрээ арчсан бэ?
 - Эмэгтэй тэр орой нэг ч үг хэлээгүй, гэвч түүний байгаа байдал нь юуг хэлж байсан бэ?
7. 41-42 дугаар ишлэл дээр Есүс мөнгө зээлдүүлэгч болон мөнгө зээлэгчийн тухай бяцхан сургаалт зүйрлэл ярьжээ. Мөнгө зээлдүүлэгч нь Бурхан байсан бол 2 мөнгө зээлсэн хүнээр хэнийг хэлсэн байж болох вэ?
 - Есүс гэм нүгэлийг эргэлзээ болон өртэй харьцуулж байна. 500 денарын өр нь энгийн ажилтаны жил хагасын цалинтай тэнцэх бөгөөд 50 денар нь 1 сар хагасын цалинтай тэнцэх юм. Бидний үед энэ нь хир их мөнгө вэ?
 - Таны амьдралдаа хийсэн гэм болгоныг 100 төгрөгөөр үнэлээд түүнийгээ өр гэж бодвол та өнөөдөр Бурханд хир их өртэй вэ? (Та дотороо хариулж болно.)
8. Симон яагаад Есүс болон Эмэгтэй хоёрыг үзэн ядсан бэ? (39)
 - Бид нарт яагаад бусдын гэм нүгэлийг олж харах нь өөрсдийн гэмийг харахаас илүү амархан байдаг вэ?
9. Аль нь эхэлж болсон бэ: Эмэгтэй эхэлж өөрийнх нь гэм нүгэл уучлагдсан гэдэгт итгэсэн үү эсвэл гэм нүгэлийг уучлалыг авахын тулд эхэлж Есүсийг хайрласан уу? (42-43, 47 ишлэлүүдийг уншаад олон янзын хариултыг ол)
 - Бурханд өртэй байсан эмэгтэйн өрийг хэн төлсөн бэ?
 - Симоны Бурханд өртэй байсан өр нь юу болсон бэ?
 - Бүх хүмүүсийн өрийг Есүс ямар зүйлээр төлсөн бэ?

Баярт Мэдээний асуулт: Есүс таны бүх гэм нүгэлийг мэддэг ч тэднийг үл хайхран танд “ гэм нүгэл чинь уучлагдсан. Итгэл чинь таныг аварлаа. Амар тайван явдаа” гэж хэлж байна. (48-50). Зөвхөн түүнд л энэ үгийг хэлэх эрх байдаг. Учир нь тэр таны гэм нүгэлийн өрийг өөрийн цусаар төлсөн. Та түүнд ямар хариулт өгөх вэ?(та дотороо хариулж болно)

- (Бүгд хариулах хэрэгтэй): Энэ сэдэвээс та юу ойлгож авсан бэ?

4. Есүс улс төрчтэй тааралдсан нь (Марк 10:17-27)

Суурь ойлголт: Энэ хүнийг маш залуу парламентийн гишүүн гэж бусад Сайн Мэдээний номонд бичсэн байдаг. (Агуу зөвлөл хэмээх нэртэй) (Матай 19:22, Лук 18:18) Үхлийн дараа тэр мөнхийн улсад эсвэл мөнхийн там руу явна гэдгээ мэдэж байсан. Тухайн үед Израйлийн соёлд ямар ч эрэгтэй хүн өөр нэгэн эрэгтэй хүний урд гүйн очиж өвдөг сөгддөггүй байсан.

1. Таны бодлоор хүн үхлийн дараа юу болохоо мэдэлгүйгээр аз жаргалтай байж чадах уу?
 - Залуу улс төрч Есүсийн хойноос гүйн ирж өвдөг сөгдөхөд юу нөлөөлсөн бэ? (17)
 - Залуу эр Есүсийг Бурхан гэж бодсон уу эсвэл нэг ер бусын мэргэн хүн гэж бодсон уу?
(176-18)
 2. Амьдралынхаа турш Бурханы тушаалуудыг дагасан боловч мөнх амийг авна гэдэгт итгэлгүй байсны учир юу вэ?
 - Бид яагаад үхлийнхээ дараа мөнхийн улсад очино гэдэгт эргэлздэг вэ?
 - Бид үхлийнхээ дараа мөнхийн улсад очино гэдэгт итгэлтэй байж болох уу?
(Шалтгаанаа тайлбарла)
 3. Таны бодлоор Есүс 19-р ишлэл дээр ямар тушаалыг дагах нь хамгийн хэцүү гэж хэлсэн вэ?
 - Олон улс төрчид мөнгө болон завхайрлийн тал дээр уруу татагддаг. Яаж залуу улс төрч эдгээр уруу татлагад автахгүй байж чадсан бэ?(20)
 - Бурханы хуулиудыг ажил үйлс дээрээ төдийгүй бодол санаа, хэл яриандаа хэрэгжүүлэх ёстой гэж Есүс хэлсэн. Энэ бүхнийг тэр залуу дагасан болов уу?
(19-20)
 - 20-р ишлэл дээрх зүйлсийг энэ залуугын адил та хэлж чадах уу?
 4. Залуугын хувьд (Бурхантай тогтоосон харилцаанд нь) нэг зүйл дутуу байсан. Тэр нь юу байсан бэ?(21)
 5. 21-р ишлэл дээр Есүс тэнгэрийн баялагийн тухай ярьж байна. Бид яаж тэнгэрийн улсад баялаг хуримтлуулах вэ?
 - Энэ дэлхийн баялагийг тэнгэрийн баялагтай харьцуулж үзвэл ялгаа нь юунд байна вэ?
 - Өнөө үеийн залуучууд юуг хамгийн эрхэм зүйлээ болгодог вэ?
 - Таны хувьд юу чинь хамгийн эрхэм бэ? (Дотороо хариулж болно)
 6. Энэ залуу гэр бүлтэй, асарч хандах настай эцэг эхтэй байсан байх. Хэрвээ тэр Есүсийн (21) хэлсэн зааврыг дагасан бол гэр бүлийх нь яах байсан бол?
 - Хэрвээ та энэ залуугын оронд байсан бол Бурхан ямар ч үед таны эхнэр, хүүхэд эцэг эхийг тань халамжилж, санаа тавина гэдэгт итгэж чадах уу?
 - Та өөрийн дэлхий дээрх эд баялагаасаа татгалзаж ингэснээрээ тэнгэрт эд баялагийг цуглуулж чадна гэж бодож байна уу?
 7. 21-р ишлэл дээр Есүс тэр залууг хайрласан гэж байна. Гэвч яагаад Есүс тэр залууг явахаар хатуу үгс хэлсэн бэ?
 8. Есүсийн шаардсан зүйлийг биелүүлж чадахгүйгээ мэдсэн тэр залуу Есүсийг орхиж явахаас гадна өөр ямар сонголт хийж болох байсан бэ?(22)
 9. Энэ мөчөөс эхлэн залуугийн амьдрал ямар байсныг төсөөл. Тэр жаргалтай байсан уу? Үхлийнхээ талаар юу гэж боддог байсан бол?
 - Баян залуу Петр хоёрт өгсөн Есүсийн хариултыг харьцуул (21, 27). Хариулт нь адилхан байна уу эсвэл өөр байна уу?
 - Хэн үхлийнхээ дараа тэнгэрийн улсад очиж болох вэ?
- Баярт Мэдээний Асуулт:** “Бурханд бүх юм боломжтой”: Есүс энэ дэлхийд ирж бидэнд тэнгэрийн улсын билетийг өгөхийн тулд тэнгэрт байгаа баялагаасаа татгалзсан юм. Энэ хүн Есүсийг орхин явснаараа маш том алдаа хийсэн. Та юу хийх вэ? (Дотороо хариулж болно)
- (Бүгд хариулах ёстой): Энэ сэдэвээс та юу ойлгож авсан бэ?

5. Есүсийн сургаал: Төөрсөн хүү (Лук 15:11-24)

Суурь ойлголт: Есүсийн ярьсан бүх түүхийг сургаалт зүйрлэл гэж нэрлэдэг. Тухайн үед эцэг нь амьд байх үед үр удамдаа хэзээч эд хөрөнгөө өвөлдөггүй байж. Дундад дорны хүмүүс шигүү суурьшан зам дагуу амьдардаг байсан бөгөөд тэд байшингаа дов толгод дээр барьдаггүй ажээ. Алсын бараа харж болох цорын ганц газар гэвэл байшингийнх нь дээвэр юм.(20) Тэндхийн нэр хүнд бүхий хүмүүс хэзээ ч гүйдэггүй байжээ.

1. Эрх чөлөөг нь хязгаарладаг эцэг эхтэй залуу хүн аз жаргалтай байж чадах уу?
 - Сайн эцэг сайхан орон гэртээ байсан хирнээ бага хүү яагаад амьдралдаа сэтгэл хангалуун бус байсан бэ?
 - Хэрэв та эцэгийнх нь оронд байсан бол хүүгийн хүсэлтэнд хэрхэн хариу өгөх байсан бэ?(12a)
 2. Эцэг нь хүүгээ явуулснаараа юу болохыг мэдсэн боловч хүүгээ явах үед яагаад гуниг уйтгарлаа нуусан бэ? (12б)
 - Энэ тохиолдолд эцэг нь Бурхан, хүү нь магадгүй баптисм хүртсэн итгэгч хүмүүсийг төлөөлсөн байна. Өөрийг нь орхиж явахаар зэхэж буй хүнд Ертөнцийн Эзэн яагаад хориг тавьж саад хийдэггүй вэ?
 3. Өнөө үеийн ихэнх залуучууд яагаад энэ хүүгийн адил буруу замыг сонгодог вэ – ганцаараа хаа сайгүй аялан тэнүүчилж, хариуцлагагүй бас их мөнгөтэй байх замыг сонгодог вэ?
 - Энэ залуу эцэгийнхээ мөнгийг яаж үрсэн бэ? 13-30 дугаар ишлэлийг хар.
 - Бага хүүд хэцүү байх үед түүний талд зогсож түүнд дэмжлэг өгөх найз яагаад байгаагүй вэ?
 4. Еврейчүүд гахайг бузар амьтанд тооцдог байжээ. Гахай хариулах ажилаа хийх үед тэр юу гэж боддог байсан бол?(14-15)
 - Хүү маш их өлссөн мөртлөө яагаад гахайн хоол идэхийг хүсээгүй вэ? (16)
 5. Энэ хэцүү цаг хугацаанд тэр сэтгэл санаагаараа унаж амиа хорлоогүй харин ч ухаан ороход нь юу нөлөөлсөн бэ?(17)
 - Тэнгэрийн эсрэг түүний үйлдсэн гэм нь юу байсан бэ? (18)
 - 18-19 ишлэл дээр хүү нь эцэгийнхээ өмнө гэмшинэ гэж төлөвлөж байсанийг хэлсэн байна. Эцэгийнхээ эсрэг үйлдсэн гэм нүгэл нь юу бэ?
 - Та тэнгэрийн эсрэг ямар гэм үйлдсэн бэ? Эцэг эхийнхээ эсрэг ямар гэм үйлдсэн бэ? (Дотроо хариулж болно)
 6. Эцэгээсээ эргэж хүү нь болоё гэж гуйхыг тэр яагаад хэзээч бодоогүй бэ? (19)
 - Ямар хүмүүс "бид нар Бурханы хүү хэмээгдэх зохисгүй" гэж боддог вэ?(19)
 7. Эцэг нь хүүгээ хөл нөцгөн урагдсан даавуу өмсчихсэн гэр рүүгээ ирж байхыг хараад юу гэж бодсон бол?(20)
 - Эцэг нь хүүгээ холоос танихад юу саад болсон бэ?(20) (Суурь ойлголтыг унш)
 - Хүүгээ эзэгүй эдгээр жилүүдэд эцэг нь юу хийж байсан бол? (20)
 8. Хүү эцэгтээ хэлэхээр төлөвлөж байсан үгээ яагаад бүгдийг нь хэлээгүй вэ?(18-19, 21)
 - Эцэгийнх нь гаргаж байсан зан ааш хэлж байсан үгс хүүгийн хувьд ямар утгатай байсан бэ?(22-23)
 - Эцэг нь хүүгээ хэдийд уучилсан гэж та бодож байна вэ? (Ишлэлийг ол)
 - Хүү нь эцэгийнхээ хайранд хэдийнээс итгэж эхэлсэн бэ? (Ишлэлийг ол)
 - 24 –р ишлэл дээрх Эцэгийн хэлсэн үгс нь ямар утгатай байсан бэ?
 9. Бурханы хайр хүмүүсийн хайраас юугаараа ялгагддаг вэ?
 - Энэ сургаалт зүйрлэл бидэнд өөрчлөлтийн тухай юу зааж байна?
- Баярт Мэдээний Асуулт:** "Миний хүү үхсэн байсан харин тэр дахин амилсан" Есүс ч бас Эцэгийнхээ хүслийг биелүүлэхийн тулд гэрээ орхин энэ дэлхий дээр ирсэн билээ. Харин түүнийг гэртээ эргэн очиход үрэлгэн хүүг угтсан шиг зочлол байсангүй. Харин ч түүний өмнө хаалга чангаар хаагджээ. Яагаад Есүс үрэлгэн хүүгийн явах байсан замаар явах болсон байсан бэ?
- (Бүгд хариулах ёстой асуулт): Энэ сэдэвээс та юу ойлгож авсан бэ?

6. Есүсийн сургаал: Өөр нэгэн төөрсөн хүү (Лук 15:25-32)

Суурь ойлголт: Үнэндээ эцэг нь бага хүүдээ хөрөнгөнийхөө талыг нь өгсөн ч үлдсэнийг нь том хүүдээ өгөх байсан (12). Том хүү эцэгийнхээ үгэнд итгээгүйд эцэгийнх нь буруу биш байсан.

1. Эцэг эх нь өөрт нь хайргүй гэж боддог залуу хүмүүс жаргалтай байж чадах уу?
 - Том хүү жаргалгүй байсан бол яагаад дүүтэйгээ хамт гэрээ орхин яваагүй вэ?
 - Энэ хүн амьдралдаа юуг бүхнээс илүүтэйгээр хүсэж байсан бэ?
 2. Том хүү өөрийгөө өв залгамжлагч гэхээсээ илүү зарц барлаг мэтээр үздэг байсан нь юуных вэ?(126, 29, 31)
 - Энэ сургаал зүйрлэл дээр Эцэгийг Бурханаар, бага хүүг Христэд итгэх итгэлээ алдсан хүн гэж төсөөлсөн бол том хүү ямар хүнээр төсөөлөгдсөн бэ?
 - Эцэг нь Хүү нартайгаа шудрагаар хандсан гэж та бодож байна уу?
 - Бурхан бидэнтэй үргэлж шудрагаар ханддаг гэж та бодож байна уу?
 3. Том хүү өдөр бүр талбай дээр их хөдөлмөр гаргасан гэж бодоход нь юу нөлөөлсөн бэ?
 - Танд 29-30 дугаар ишлэл дээр гарч байгаа том хүүгийн адил сэтгэгдэл төрч байсан уу? Тийм бол ямар тохиолдолд вэ?
 - Найз нөхөдтэйгээ баярлаж цэнгэмээр байгаагаар том хүү нь хэзээ ч илэрхийлдэггүй байсан учир юу вэ? (29)
 - Том хүү найзууддаа зориулан ямаа, хонь эсвэл тугал нядалж найр хийсэн бол эцэгт нь ямар сэтгэгдэл төрөх байсан бол? (30-31)
 4. Том хүүгийн муухай ааш зан гаргасан шалтгаан нь юу вэ? (27-28)
 - Хоёр хүү хоёулаа эцэгийнхээ нүүрийг бусадын өмнө улайлган эвгүй байдалд оруулсан. Гэтэл эцэг нь үүнд яагаад уурлаагүй вэ?
 - 286, 31-32 дугаар ишлэлийг харахад эцэгийн талаар танд ямар сэтгэгдэл төрж байна?
 - 286, 31-32 дугаар ишлэлийг харахад Бурханы талаар танд ямар сэтгэгдэл төрж байна?
 5. Эцэг нь том хүүгээ маш ихээр хайрласан боловч хүү яагаад эцэгийгээ хайрлаагүй вэ?
 - Энэ сургаалт зүйрлэлийн гол утгыг нь ярилц. Ямар шалтгаанаас болж бид Бурханыг хайрладаггүй вэ?
 6. Том хүү өөрийгөө “Би таны хэлсэн үг болгоныг биелүүлдэг” гэжээ (29). Эцэг нь хүүгээсээ өөртөө хэрхэн хандаасай хэмээн хүсэмжилж байсан бэ?
 7. Яагаад Есүс том хүүг найранд оролцсон үгүйг хэлэлгүй сургаалаа дуусгасан бэ? (28-32)
 8. Есүсийн сургаалт зүйрлэлүүдэд гарч байгаа ихэнх найр наадам нь мөнхийн улсыг төлөөлсөн байдаг. Энэ сэдвээс үзэхэд хэн нь мөнхийн улсад очиж чадах вэ?
 - Энэ сургаалт зүйрлэлийн дагуу хэрвээ хэн нэгэн нь тэнгэрийн улсад очиж чадахгүй бол хэний буруу болох вэ?
 9. Маргааш өглөө нь ах дүү хоёр талбайд ажиллахаар хамт явлаа гэж бодоход тэдний бодол санаа хэр зэрэг зөрөөтэй байсан гэж та бодож байна?
 - Дэлхийн бүх хүмүүс энэ сургаалт зүйрлэл дээр гарч байгаа ах дүү хоёрын аль нэгэнтэй нь төстэй байдаг. Та өөрийгөө алинтай нь төстэй гэж бодож байна вэ? (Та дотороо хариулж болно)
- Баярт Мэдээний асуулт:** Есүс танд хандаж “Миний гэсэн бүх юм чинийх” гэж айлдсан юм. Загалмайд цовдлогдох үед Есүс танд тэнгэрийн улсад орон тоо олж өгсөн юм. Таныг Баптисм хүртэж байх үед чинь тэр танд үүнийг өвлөсөн юм. Харин том хүү энэ амлалтанд итгээгүй. Тэр өөрөө боолын байр суурийг өвлөсөн юм. Та тэнгэрийн улсад очихын тулд зүгээр л суух уу эсвэл та сайн үйлс хийх үү?(Та дотороо хариулж болно)
- (Бүгд хариулах хэрэгтэй): Энэ сэдвээс та юу ойлгож авсан бэ?

7. Есүсийн сургаал: Миний хөрш хэн бэ? (Лук 10:25-37)

Суурь ойлголт: Иерусалимаас Иерихо хүртэлх зам нь 30км зайтай байсан бөгөөд дээрэмчид аялагчидыг замд нь отож дээрэмддэг байсан учираас маш аюултай байдаг байж. Сүмд манаач хийдэг байсан хүмүүсийг Лэви хүн гэдэг байжээ. Тухайн үед Еврейчүүд Самаарчуудтай хамт нэг газар нутагт амьдардаг байсан боловч тэд өстөн дайснууд байж. (Та өөрийнхөө нутгийг жишээ болгож үз. Жишээлбэл Монгол улс: Самаарчуудыг Хятад хүмүүс бусадийг нь Монгол хүмүүс гэж бодож үзвэл танд энэ сургаал зүйрлэл илүү ойлгожтой байх болно.)

1. Хэрвээ хүн зөвхөн гэр бүлдээ санаа тавьж өөрийнхөө зовлонд ердөө анхаарахгүй байх юм бол тэр хүн жаргалтай амьдарч чадах уу?
 - Та ядуу хүмүүсд зориулан хир их мөнгө зарцуулдаг вэ?
2. Өмнөх хичээл дээр бид нэгэн улс төрчийн тухай үзсэн, тэр хүн энэ хуулийн багш хоёр хоёулаа адилхан асуулт тавьсан байна. “Тэнгэрийн улсад очих зам нь юу вэ” гэсэн асуултанд хэрхэн хариулсаныг хар.(25-27)
 - Есүсийн 27-р ишлэл дээр айлдаж байгаатай адилхан болзолтойгоор Тэнгэрийн улсад очих ямар боломж танд байна вэ?
3. Есүс сургаалт зүйрлэлдээ нэгэн зодуулсан залуугийн тухай өгүүлж байна. Зодуулсан залуу зам дээр хэдэн цагаар хэвтэж байх үедээ юу гэж бодсон бол?
 - Амласан цагтаа ирээгүй аавыгаа эхнэр хүүхэд нь юу гэж бодож байсан бол?
4. Явган хүмүүс зодуулсан хүнд туслах нь яагаад аюултай вэ?
 - Тахилч бас Лэви хүн хоёр сүмд үйлчилдэг байсан учир үүргээ биелүүлэхийн тулд тэр замаар явж байв. Зодуулсан хүн энэхүү 2 хүний төрсөн хүү нь байсан бол тэд яах байсан бол?
 - Гэмт хэрэгт хохирсон хүнд туслаагүй тэрхүү хоёр хүнд ямар шалтгаан байж болохыг бодож үз. (31-32)
 - Та ийм нөхцөл байдалд байсан бол яах байсан бэ?
5. Хүүхэд байхаасаа хайрын тухай хуулийг сонсож байсан боловч энэ 2 хүн энэ хуулийг хэрхэн ойлгосон бэ? (27-р ишлэлийг хар)
 - “Би Бурханыг бүх сэтгэл зүрхээрээ хайрладаг, гэхдээ надад бусад хүмүүсд туслах ямар ч боломж байхгүй” гэж хэлсэн хүнийг та юу гэж бодох вэ?
6. Хэрвээ Самари хүн Ерьей хүний хажуугаар өнгөрсөн бол тэр яаж өөрийгөө зөвтгөх байсан бэ? Суурь ойлголтыг хар.
 - Энэ нөхцөл байдалд Самари хүн бусад хүмүүсийн өгч чадахгүй, өөр ямар нэмэлт тусламж үзүүлсэн бэ?(33-35)
7. Хоёрхон өдрийн хөлсөнд 2 мөнгөн зоос үлдээсэн нь нэг хүний бүтэн 2 сарын буудлын хөлстэй тэнцэх мөнгө ажээ. Энэ нь манай ханшаар хир их мөнгө вэ?
 - Самари хүн огт танихгүй хүнд яагаад ийм их хэмжээний мөнгө өгсөнийг та олон талаас нь авч үз.
 - Таны бодлоор Самари хүн хайрын тухай хуулийн хэдэн хувийг нь биелүүлсэн бэ? (27-ишлэлийг хар)
8. “Хөрш” гэж Есүс хэнийг хэлсэн бэ?
 - Таны ойрын бас холын туслах ёстой хөрш чинь хэн бэ?
9. Таныг энэ дүрүүдийн нэгийг нь сонго гэвэл тэ алийг нь сонгох вэ?: Зодуулсан хүн үү, дээрэмчинийг үү, тахилчыг уу, Лэви хүнийг үү эсвэл дэн буудалын эзэнийг үү? Та яагаад энэ хүнийг сонгосон шалтгаанаа хэлнэ үү?
 - Энэ сургаалт зүйрлэл дээр Есүс Самари хүнтэй юугаараа төстэй вэ?
 - Есүс зодуулсан хүнтэй юугаараа төстэй вэ?
 - 27-р ишлэл дээр Есүс тэнгэр рүү очих бас нэгэн өөр замыг тодорхойлсон байна. Тэр зам нь ямар зам бэ?

Баярт Мэдээний асуулт: “Явж үүний адил үйлд” гэж Есүс хэлсэн байна. Бүх хүмүүс танд санаа тавьдаггүй, хажуугаар чинь өнгөрдөг байсан бол, Есүс үүнийг хийхгүй. Тэр одоо ч таны хажууд зогсож таны сэтгэлийн шархыг чинь эдгээхийг хүсч байна. Та тэрэнд юу гэж хариулах вэ? (Та дотороо хариулж болно.)

- (Бүгд хариулах хэрэгтэй): Энэ сэдэвээс та юу ойлгож авсан бэ?

8. Есүс 2 дээрэмчинтэй уулзсан нь (Лук 23:32-43)

Суурь ойлголт: Есүсийн үед зөвхөн ноцтой гэмт хэрэг хийсэн хүмүүсийг цовдолдог байжээ. Тэгвэл энэ хоёр мэргэжлийн дээрэмчид мөнгөнөөс болж хүн алсан юм уу эсвэл өөр ямар нэгэн ноцтой гэмт хэрэг хийсэн бололтой. Хуучин гэрээний үеэс хойш Иүдэйчүүдийн хүлээж байсан хааныг Мэссиа гэдэг байжээ.

1. Бусдыг нударгаараа цохисон эсвэл үг хэлээрээ гомдоосон хүн аз жаргалтай байж чадах уу?
 - Өнөө үеийн залуучуудад гэмт хэрэг үйлдэх бусдыг бүлэглэн дээрэмдэх нь яагаад таалагддаг вэ?
2. Энэ хоёр хүнийг хулгай хийх, хүн алах гэх мэт нүглүүдийг үйлдэх болсон шалтгаан нь юу вэ?
 - Энэ 2 хүнийг гэмт хэрэг үйлдэхээс нь өмнө хэн болиулж чадах байсан бэ?
 - Таны зан чанар чинь бусдад бас өөрт чинь хор хөнөөлтэй байсан бол та өөрийгөө өөрчилж чадах уу?
3. Тэр 2 дээрэмчин Есүсийг цовдлогдож байх үед бусдаас илүү ойрхон байсан учираас тэд Есүсийн зан чанарыг ажигласан байх. Есүсийн хэлсэн ямар үг мөн ямар үйлдэл нь тэднийг гайхшруулсан бэ? (34-38)
 - Есүс яагаад өөрийг нь зовоож байсан хүмүүсийг тэнгэрлэг эцгээсээ хамгаалсан бэ? (34)
 - Та өстөн дайсныхаа төлөө гуйн залбирч чадах уу? “Бурхан минь та түүнийг өршөөгөөч. Тэр намайг цохисоноороо гэм нүгэл хийсэн гэдгээ өөрөө ч мэдэхгүй”. (34)
4. Энэ ишлэлүүдээс захирагчид, цэргүүд бас загалмайд цовдлогдсон хоёр хүний нэг нь Есүс рүү юу гэж хашгирсаныг ол.(34б-39)
 - Юунаас болж тэд Есүсийг тохуурхаж байсан бэ? (35-39)
 - Яагаад Есүсийн найз нарын алин ч түүнийг өмөөрөөгүй вэ?
 - Та тухайн үед загалмайн доор зогсож байсан бол юу хийх байсан бэ?
5. Хоёр гэмт хэрэгтний нэг нь Есүсийг хаан мөн өөрийн гэсэн хаанчлалтай гэж бодсоны учир юу вэ? (37-38)
 - Энэ дэлхийн хаадуудтай харьцуулахад Есүс юугаараа илүү их эрх мэдэлтэй хаан бэ?
 - Тэдний нэг нь Есүсийг зөвхөн хаан биш Бурхан мөн гэж бодсоны учир юу вэ?(40)
6. Ихэнх гэмт хэрэгтэнгүүд буруу хийсэн зүйлээ хүлээн зөвшөөрдөггүй. Үхлийн шийтгэл авсан нь хийсэн гэмт хэрэгийнхэн зөв шийтгэл гэдэгийг хүлээн зөвшөөрөхөд юу нөлөөлсөн бэ?(41)
 - Нөгөө дээрэмчин нь яагаад гэм нүгэлээ хүлээн зөвшөөрөөгүй вэ?
 - Энэ 2 гэмтний хэнийг нь та илүү ойлгож байна вэ?: Гэмт хэргээ хүлээн зөвшөөрсөнийг нь үү эсвэл эсэргүүцсэнийг нь үү?
7. 42-р ишлэл дээрх богино залбирал нь: “Намайг санаарай”. Зовлонд унасан үед бид хайрладаг хүмүүсээсээ “Намайг санаарай” гэж яагаад хүсдэг вэ?
 - Энэ дээрэмчин яагаад Есүсээс шууд тэнгэрийн улсад очихыг хүсэж байгаагаа хэлээгүй вэ?
8. 43-р ишлэл дээрх өгсөн Есүсийн хариултыг тэд сонсоод юу гэж бодсон бол?
 - Есүс энэхүү алуурчиныг яагаад тэнгэрийн улсад очихыг зөвшөөрсөн бэ?
 - Уг гэмт хэрэгтэн хэдийд итгэж эхэлсэн бэ? (Ишлэлийг ол)
9. Есүс итгэсэн гэмт хэрэгтний амьдралынх нь сүүлчийн хэдэн цагийг төсөөлж үз. Энэ цагуудад тэр аз жаргалтай байсан уу эсвэл гунигтай байсан уу?
 - Гэмт хэрэгтний ээж нь, эхнэр нь эсвэл хүүхэд нь загалмайн доор зогсож байсан гэж бодвол, тэр хүн гэр бүлдээ өөрийнхөө талаар ямар дурсамж үлдээсэн бол?
 - Энэ хүн ирээдүйн Библи унших хүмүүст ямар гэрчлэл үлдээсэн бэ?

Баярт Мэдээний асуулт: Дээрэмчиний хувьд тэнгэрийн улсын хаалга нээлттэй байсан боловч Есүс тамын хаалгаар орох ёстой болсон. Та ч гэсэн “Есүс ээ намайг санаарай” гэж залбирахыг хүсвэл, тэр танд мөн “Нэгэн өдөр чи надтай диваажинд хамт байх болно” гэж хариулна.

- (Бүгд хариулах хэрэгтэй): Энэ сэдэвээс та юу ойлгож авсан бэ?

9. Итгэл муутай шавь (Иохан 20:19-29)

Суурь ойлголт: Томас Есүсийн 12 дагалдагч нарын нэг байсан юм. Магадгүй Томас ихэр байсан байх. Яагаад гэвэл түүний нэр нь “ихэр” гэсэн утгатай юм.

1. Хамгийн сүүлийн өдөр бидний бие булшнаасаа босох болно гэдэгт итгэдэггүй хүмүүс жаргалтай амьдарч чадах уу?
 - Томасын зан чанарт ямар сайн шинжүүд байсан бэ? Ямар муу шинжүүд байсан бэ?
 - Есүс яагаад энэ хүнийг шавь нарынхаа нэгээр сонгосон гэж та бодож байна вэ?
 2. Есүсийн дахин амилалтын өдрийн өглөө нь шавь нар нь түүний талаар юу бодож байсан бол?
 - Дагалдагчид Есүсийн дахин амилалтанд яагаад итгээгүй вэ?
 - Томас яагаад Есүсийн дахин амилсан бүтэн сайны орой бусад шавь нарын хамт байгаагүйг янз бүрийн шалтгаанаар эргэцүүлэн бод. (24)
 3. Хэдийгээр Есүсийн дахин амилалтийг 3 зүйлээр: Хуучин Гэрээний зөгнөлүүд, Есүсийн өөрийн тухай урьдчилан хэлсэн үгс, түүний хамгийн дотны 10 найзууд санал нэгтгэйгээр баталсан ч Томас яагаад итгээгүй вэ? (25а)
 - Хэрвээ та Томасын оронд байсан бол, Есүсийн дахин амилалтанд итгэх байсан уу? Шалтгаанаа хэлнэ үү?
 4. Долоо хоногын турш дагалдан явсан баяр хөөртэй шавь нарын дунд Томасд ямар мэдрэмж төрсөн бэ?
 - Томас өөрийн замыг хөөлгүй бусад дагалдагчидтай хамт байсанд юу нөлөөлсөн бэ?
 - Хэрэв тэр энэ үед найз нараасаа явсан бол юу тохиолдох байсан бол?
 - Хэрвээ бид Христчин нөхдөө орхин явбал бидэнд юу тохиолдох вэ?
 5. Есүсийн дахин амилалтанд итгэхээсээ өмнө Томас яагаад түүнд хүрэхийг хүссэн бэ?(25б)
 - Есүс Томасын хэлсэн үгийг (25-27 дугаар ишлэл дээр) давтан хэлэхэд Томасд ямар мэдрэмж төрсөн бол?
 6. Есүс сүнс эсвэл Ариун сүнс биш гэдгийг ямар зүйлүүд бидэнд харуулж байна вэ?
 - Томас үнэхээр Есүсийн гар дахь хадаасны ормонд нь хуруугаа хийн, Түүний хажуу уруу нь гараа хийж үзсэн болов уу?
 7. Томас Шинэ Гэрээнд Есүсийг “Бурханы Хүү” гэж биш, “Бурхан” гэж дуудсан анхны хүн байсан (28). Дэлхийн бүх итгэгчид яагаад Есүсийг Бурхан гэж боддог вэ?
 8. Есүс 29-р ишлэл дээр хэний талаар юуг өгүүлж байна вэ?
 - Хараагүй, мэдрээгүй байсан ч Бурханы өршөөл ба тусламжинд итгэх нь яагаад чухал вэ?
 9. Энэ хэсэгээс үзвэл, Есүс түүнд итгэхийг хүссэн боловч итгэж чадахгүй хүнтэй хэрхэн ханддаг вэ?
 - “Би Есүст итгэж байна гэхдээ түүний дахин амилалтанд итгэж чадахгүй.” гэж хэлсэн хүнд та ямар хариулт өгөх вэ?
- Баярын Мэдээний асуулт:** Томас Есүс рүү хандан: “Эзэн минь, Бурхан минь” гэж хэлсэн. Та өнөөдөр үүний адил гэмээ хүлээн зөвшөөрч чадах уу? (Та дотороо хариулж болно)
- (Бүгд хариулах хэрэгтэй): Энэ сэдэвээс та юу ойлгож авсан бэ?